

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Авто замын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10, 27 дугаар зүйлийн 27.2, 27.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх, мэдээлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, бүртгэлээс хасах ажлыг батлагдсан журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, баяжуулалт хийж ажиллахыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Р.Буд/-т, хариуцсан замын бүртгэл мэдээллийн санг хөтөлж, гарсан өөрчлөлт бүрийг тухай бүр нэгдсэн бүртгэлд оруулж байхыг зам хариуцагч нарт тус тус даалгасугай.
3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан ... хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Я.СОДБААТАР

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ОЛОН УЛС, УЛСЫН БОЛОН ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТО ЗАМЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ЭРХЛЭН ХӨТЛӨХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх олон улс, улсын болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжид тооллого, бүртгэл хийх, үндсэн хөрөнгийн бүртгэлд авах, авто замын сүлжээний техникийн үзүүлэлт, ашиглалтын түвшний талаарх өгөгдлүүдийг үндэслэн, зохих программ хангамжийг ашиглан бүртгэл мэдээллийн нэгдсэн сан байгуулах, эрхлэн хөтлөх, баяжуулах, мэдээлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад мөрдөнө.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг бүртгэж, замын паспорт, гүүрийн картыг хөтлөн, авто замын сүлжээний техник ашиглалтын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгийн тухай мэдээллийг төвлөрүүлэх, нэгтгэх, боловсруулах, баяжуулах, баримтжуулах, мэдээллийн санд төвлөрсөн мэдээлэлд үндэслэн төлөвлөлт, дүгнэлт, дүн шинжилгээ хийх, эх бэлтгэх, авто зам, замын байгууламжийн барилга, засвар, арчлалтын ажлыг оновчтой төлөвлөх, зохион байгуулахад хэрэгцээт мэдээлэл, тоон өгөгдлийг цуглуулах, хяналт тавих, олон түвшний зам хэрэглэгчдийг мэдээллээр хангах, авто замын сүлжээний ашиглалтын төлөв байдлыг тогтоох зорилгоор бүртгэл мэдээллийн санг байгуулах, баяжуулах, хөтлөх, ашиглахад энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

2.2. Тоон болон газарзүйн мэдээллийн санг нэгтгэсэн Монгол Улсын авто замын сүлжээний зураг, хүснэгтэн болон бусад цогц мэдээллийг агуулсан, программ хангамж, техник хангамжийн тусламжтайгаар мэдээллийг цуглуулах, хадгалах, нэгтгэх, боловсруулах, удирдах, ашиглах боломж бүхий орон зайн мэдээллийн цахим санг бүртгэл мэдээллийн сан (цаашид “мэдээллийн сан” гэх) гэнэ.

2.3. Авто зам, замын байгууламжийн бүртгэл, мэдээллийн санг эрхлэн хөтөлж, нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах үйл ажиллагааг Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага хариуцан зохион байгуулна.

2.4. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр бүртгэл мэдээллийн санг хөтлөх, баяжуулах үүргийг шаардлага хангасан мэргэжлийн байгууллагад эрх шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

Гурав. Мэдээллийн сан, сүлжээний бүтэц, зохион байгуулалт

3.1. Мэдээллийн сангийн хэрэглэгчдийг тодорхой түвшинд ангилах бөгөөд ангилал тус бүрд хэрэглэгчийн түвшинтэй байна. Хэрэглэгчийн түвшин, ажиллах хүрээг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. Үүнд:

Админ хэрэглэгч: Мэдээллийн санг удирдах, мэдээллийг ашиглах, засварлах, баяжуулах эрхтэй байна. Үүнд: Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүд байх бөгөөд Админ хэрэглэгчийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилно.

Мэргэжлийн хэрэглэгч: Хариуцсан авто зам, замын байгууламжийн талаарх мэдээллийг харах, ашиглах, засварлах, баяжуулах эрхтэй зам хариуцагч байгууллагын ерөнхий инженерүүд байна. Мэргэжлийн хэрэглэгчийг Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагаас томилж, мэдээллийн санг хөтлөх арга зүйн зөвлөмжөөр хангана.

Энгийн хэрэглэгч: Мэдээллийн санд нэвтэрч авто зам, замын байгууламжийн талаарх ерөнхий мэдээллийг харах эрхтэй зам хэрэглэгч, ашиглагч, зорчигчид байна.

3.2. Админ нь мэргэжлийн туршлага, техникийн нөхцлөөр хангагдсан мэргэжилтэн байна. Үүнд: Газарзүйн мэдээллийн систем дээр ажиллах чадвартай /ArcGis зэрэг дэвшилтэт программ хангамжийн мэдлэгтэй/, Газарзүйн мэдээллийн системийн орон зайн анализ хийх, Network analyst, Geocoding өргөтгөлүүдтэй ажиллах үндсэн мэдлэг, туршлагатай байх

3.3. Админ мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжуулалтын тайланг жил бүр авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаасан болон цахимаар хүргүүлнэ.

3.4. Мэргэжлийн хэрэглэгч нь өөрийн ажил үүргийнхээ хүрээнд мэдээллийн санд хандах эрх нээлгэх тохиолдолд дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.4.1 Мэдээллийн санд хандах эрх нээлгэх, хаалгах хүсэлтээ Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагад албан бичгээр гаргасан байх;

3.4.2 Мэдээллийн сангийн программ хангамжийн сургалтанд хамрагдаж, ашиглалтын гарын авлагатай танилцаж, заавар зөвлөгөө авсан байх;

3.4.3 Мэдээллийн сангийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг чанд хадгалах, шинээр оруулсан мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг бүрэн хариуцах;

3.5. Мэргэжлийн хэрэглэгч нь ажил үүргээ гүйцэтгэж, замын үзлэгээр явах үед олж авсан мэдээлэл нь мэдээллийн сангийн өгөгдлөөс зөрж байгаа тохиолдолд үнэн зөв байдлыг нягтлан, холбогдох нотолгоо баримтын хамт Админ хэрэглэгчид мэдэгдэнэ.

3.6. Мэргэжлийн хэрэглэгч нь шилжсэн, өөр ажилд томилогдсон болон чөлөөлөгдсөн тохиолдолд Админд мэдээлэх үүрэгтэй.

Дөрөв. Мэдээллийн сангийн бүтэц

4.1. Мэдээллийн сан нь тоон болон газар зүйн мэдээллийн сангаас бүрдэнэ.

4.1.1. Газар зүйн мэдээллийн сан нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Олон улсын чанартай авто замын мэдээлэл
- Улсын чанартай авто замын мэдээлэл
- Тусгай зориулалтын авто замын мэдээлэл
- Гүүрийн мэдээлэл
- Хоолойн мэдээлэл

- Төлбөр авах цэгийн мэдээлэл
- Авто пүүний мэдээлэл
- Хөдөлгөөний эрчмийн тооллогын мэдээлэл
- Шуурхай ажлын хэсгийн мэдээлэл
- Хар цэгийн мэдээлэл
- Авто замын зурвас газрын мэдээлэл
- Бусад

4.1.2. Тоон мэдээллийн сан нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Авто замын бүртгэл, паспортжуулалт
- Гүүрийн карт
- Хоолойн карт
- Гүүрийн үзлэгийн мэдээлэл
- Авто зам, замын байгууламжид хийсэн засвар арчлалтын мэдээлэл
- Төлбөр авах цэгийн мэдээлэл
- Төлбөр авах цэгүүдийн орлого, зарлагын мэдээлэл
- ~~Авто замын төлөвлөлтийн мэдээлэл~~
- ~~Гүүрийн төлөвлөлтийн мэдээлэл~~
- Засвар арчлалтын төлөвлөгөө
- Хөдөлгөөний эрчмийн мэдээлэл
- ~~Хөрөнгө-өрүүлалтын арга хэмжээний жагсаалт~~
- Хар цэгийн мэдээлэл
- Авто замын зурвас газарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын бүртгэл, мэдээлэл
- Авто зам, замын байгууламжийг барьсан болон арчлалт, засвар хийсэн байгууллагын талаарх мэдээлэл

Тав. Авто зам, замын байгууламжийн тооллого хийх, үндсэн хөрөнгийн бүртгэлд авах

5.1. **Үндсэн бүртгэл** гэж авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэмжээнд хийгдсэн авто зам, гүүрийн бүртгэл, паспорт, карт, үндсэн хөрөнгийн бүртгэлийг хэлнэ.

5.2. **Тооллого бүртгэлийн архив** гэж авто зам, гүүрийн иж бүрэн техникийн тооллого, бүртгэл, паспортжуулалттай холбоотойгоор цуглуулсан, авто зам, замын байгууламжийн эзэмшигч, өмчлөгчийн архивт хугацаагүй, тогтмол, тогтоосон журмын дагуу хадгалагдах баримт бичгийн цогцыг хэлнэ.

5.3. **Төлөвлөгөөт тооллого, бүртгэл** гэж авто зам, замын байгууламжийн үндсэн бүртгэлд анхны тооллого, бүртгэлийн дараа гарсан өөрчлөлтүүдийг газар дээр нь нарийвчлан хэмжиж тусгасан, авто зам, гүүрийн техникийн тооллого, бүртгэл, паспорт, карт, үндсэн хөрөнгийн бүртгэлийг хэлнэ. Төлөвлөгөөт тооллого, бүртгэлийг 10 жил тутам 1 удаа хийнэ. Уг тооллогоор архивт байгаа паспорт, картыг бодит байдалтай нь тулгаж, хэмжилт хийж, нэмэлт өөрчлөлтүүдийг тусгаж бүрэн шинэчилнэ.

5.4. **Төлөвлөгөөт бус тооллого, бүртгэл** гэж авто зам, гүүр шинээр ашиглалтад орох үед, зарим объектод их засвар, шинэчлэлт, хүчитгэл хийсний дараа, эсхүл тухайн объект

их хэмжээгээр эвдэрсэн, устаж үгүй болох нөхцөл үүссэн тохиолдолд, мөн эзэмшигч солигдсон үед хийгдэх үйл ажиллагааг хэлнэ.

5.6. Авто замын объектын улсын кадастржуулалт гэж Монгол улсын болон орон нутгийн засаг захиргааны хил, хязгаарын хэмжээнд авто замын объектуудыг үл хөдлөх хөрөнгийн шинж чанараар нь үл хөдлөх хөрөнгийн Улсын бүртгэлд бүртгэх эрх үүсгэх зорилгоор хийсэн, тухайн объектуудын байршил, хуулийн дагуу тогтоосон хил хязгаарын солбицолын өгөгдлүүдийг багтаасан, цаасан болон цахим байдлаар үйлдсэн баримт бичгийг хэлнэ.

5.7. Авто зам, замын байгууламжийн мэдээллийн санг хөтлөх, үндсэн хөрөнгийн бүртгэл, баяжуулалт хийх ажлыг 2 үе шаттайгаар явуулна.

5.7.1 Хээрийн хэмжилт, судалгааны ажил: Авто зам, замын байгууламжуудад ажиглалт, хэмжилт хийх, багаж хэрэгслийн тусламжтайгаар ашиглалтын техникийн нөхцлүүдийг нарийвчлан хэмжиж, тэмдэглэл хийх. Хээрийн судалгаа, үзлэг нь тухайн-өнд авто зам, хиймэл байгууламжуудад гарсан өөрчлөлт, эвдрэл гэмтэлийг илрүүлэх, тодорхойлох зорилготой.

5.7.2 Боловсруулах ажил: Хээрийн үзлэг, судалгааны материал хэмжилтүүдийг боловсруулан мэдээллийн санд нэмэлт бичилт, баяжуулалт, тэмдэглэл хийх ажлууд орно.

5.8 Авто замын паспорт, гүүр, хоолойн картыг Авто замын газрын даргын 2009 оны 24 дүгээр тушаалаар баталсан зааврын дагуу уг тушаалын хавсралт маягтын дагуу хөтөлнө.

5.9 Авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн паспорт, картанд тухайн чиглэлийн авто зам, замын байгууламжийн ажлын зураг, бусад тайлан мэдээллийг хавсаргаж болно.

5.10 Засвар арчлалтын мэдээлэлд ашиглалтанд орсноос хойш уг авто зам, замын байгууламжид хийгдсэн бүх төрлийн засварын ажлын товч тэмдэглэл, төсөвт өртөг зэргийг замын засвар хийгдсэн тодорхой хэсгүүдтэй нь уялдуулан бүртгэж тэмдэглэнэ.

5.11 Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын зам хариуцагч байгууллагууд хариуцсан авто зам, замын байгууламжид өөрчлөлт гарсан (хучилтыг хүчитгэх, ердийн хөрсөн замыг сайжруулсан хөрсөн зам болгосон, хөвөө нарийссаныг засаж өргөсгөсөн, хоолой нэмж барьсан гэх мэт) тохиолдолд паспортыг шинэчлэн, засаж, баяжуулалт хийж мэдээллийн сангийн Админд хүргүүлнэ.

5.12 Зам хариуцагч байгууллага авто замын зурвас газарт хяналт тавьж ажиллах бөгөөд зурваст үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын бүртгэлийг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор мэдээллийн сангийн Админд хүргүүлнэ. Хэрэв хууль ёсны зөвшөөрөлгүйгээр зурвас газар ашиглах, барилга байгууламж барих, зам, замын байгууламжийг эвдэх, гэмтээх, хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхүйц үйл ажиллагаа явуулсан тохиолдолд энэ талаар авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

5.13 Зам хариуцагч байгууллага ашиглах боломжгүй, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахгүй болсон авто зам, гүүрийг актлах тухай хүсэлтийг тухайн авто зам, гүүрийн эзэмшигч, өмчлөгчид хүргүүлэх бөгөөд уг байгууллагын шийдвэрээр ашиглалтаас хасах акт үйлдэж, мэдээллийн сангийн бүртгэлээс хасна.

5.14 Ашиглагдахгүй болсон гүүрийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зам хариуцагч байгууллага хариуцан буулгана.

5.15 Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлын Гүйцэтгэгч байгууллага тухайн объектыг улсын комисс ашиглалтанд хүлээн авахаас өмнө замын паспорт, гүүр, хоолойн картыг энэхүү журмаар баталсан маягтын дагуу хөтлөн Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагад хүлээлгэж өгсөн байна.

5.16 Авто зам, замын байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд Админ орж ажиллах бөгөөд авто зам, замын байгууламжийн барилга угсралт, засварын ажлын паспорт, картыг шаардлагад нийцсэн байдлаар хөтлөх, архивт хүлээлгэн өгөхөд мэргэжил арга зүйн тусламж үзүүлнэ.

5.17 Монгол улсын авто зам, гүүрийн барилга байгууламжийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг Олон улсын үнэлгээний стандарт, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль, Үнэлгээний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллого зохион байгуулах тухай санхүү төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас гаргасан тушаал шийдвэр, Зам, гүүрийн барилга байгууламжийн нэгжийн жишиг төсөвт өртөг, норм норматив болон бусад холбогдох эрх зүйн актуудад үндэслэн хийнэ.

5.18 Авто зам, замын байгууламжийн тооллого, дахин үнэлгээний хийх ажлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулах бөгөөд тооллогын үр дүнг санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран дүнг нягтлан, хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргаж, санхүүгийн тайланд тусгана.

5.19 Дахин үнэлгээг хийхдээ барилгын ажил гүйцэтгэх гэрээнд заасан төсөвт өртөг, зураг төслийн үнэ, Зөвлөх үйлчилгээний зардал, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш засвар арчлалтад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, инфляци, валютын ханшны өсөлт, үнийн өсөлтийн индекс, элэгдлийн хувь гэх мэт санхүү, эдийн засгийн болон авто зам, гүүрийн урт, насжилт, ашиглалтын байдлын үнэлгээ зэрэг техник-ашиглалтын үзүүлэлтүүдтэй уялдуулан тооцно.

5.20 Дахин үнэлгээг хийж, авто зам, гүүрийн өнөөгийн бодит үнэ цэнийг тодорхойлсон, хөндлөнгийн аудитын байгууллагаар хянагдаж, Захиалагч байгууллагаар зөвшөөрөгдсөн ~~төгтөөсөн~~ өртөг нь авто зам, гүүрийг улсын бүртгэлд авах үнэ болно.

Зургаа. Тооллого, бүртгэлийн зохион байгуулалт

6.1. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус тооллого, бүртгэлийг авто зам, замын байгууламжийн өмчлөгч, эзэмшигч /цаашид Захиалагч гэх/-ийн шийдвэрээр холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулсан хуулийн этгээд (цаашид Гүйцэтгэгч гэх)-ээр гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.

6.2. Захиалагч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчид холбогдох өөрийн архив, бүртгэл мэдээллийн санд байгаа үндсэн бүртгэлийн мэдээллийг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

6.3. Захиалагч нь авто замын төлөвлөгөөт тооллого, бүртгэлийн ажлын даалгавар, удирдамж, гүйцэтгэх аргачлалыг баталж өгөхийн хамт төрийн захиргааны бусад байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас холбогдох мэдээлэл авахад дэмжлэг, тусалцаа үзүүлнэ.

6.4. Хавсралтаар баталсан жишиг маягтууд нь үндсэн хөрөнгийн тооллого, бүртгэлийн үндсэн маягтууд болох бөгөөд Захиалагчийн шийдвэр, зөвшөөрлөөр өөрчлөлт хийж болно.

6.5. Гүйцэтгэгч Үндсэн хөрөнгийн тооллого, бүртгэлийн явцад цуглуулсан цогц материалыг цахим болон цаасаар үйлдэж, Захиалагчид хүлээлгэн өгөх бөгөөд замын паспорт, гүүр, хоолойн картыг тухайн замын засвар арчлалт хариуцсан байгууллагад тус тус хүлээлгэн өгнө. Аливаа өгөгдөлд зөрүү гарсан тохиолдолд цаасаар хадгалсан өгөгдлийг хүчинтэйд тооцно.

6.6. Мэдээллийн санд байгаа нууцлалтай мэдээллийг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр тараах, хэвлэн олшруулахыг хориглоно.

Долоо. Мэдээллийг хадгалах, архивлах, аюулгүй байдал, хамгаалалт

7.1. Мэдээллийн санг хөтлөх, баяжуулах үйл ажиллагааг тогтмол, тасралтгүй явуулна.

7.2 Мэдээллийн санг бүрдүүлэх эрх бүхий байгууллага нь мэдээллийн санг хөтөлж, өөрчлөлт гарсан тухай бүр шинэчлэн баяжуулж, мэдээллийн үнэн зөв, мэдээллийн сангийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцан ажиллах бөгөөд жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор өөрчлөлтийн тайланг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.3 Мэдээллийн сангийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах зорилгоор системийн болон мэдээллийн сангийн хандалтын түүхийг /Log/ Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн тухай бүр архивлан хадгална.

7.4. Мэдээллийн сангийн сервер бусад дагалдах хэрэгслийг засварлах, программ хангамжийг шинэчлэх, шинэ эд анги суурилуулах, шаардлагатай бусад үйлчилгээг хийхдээ зөвхөн мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтний хяналт дор мэргэжлийн итгэмжлэгдсэн ажилтан гүйцэтгэнэ.

7.5. Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагад мэдээллийн аюулгүй байдал хамгаалалт, сүлжээний төхөөрөмж, үндсэн сервер, мэдээлэл хадгалах төхөөрөмжүүд байрлах бөгөөд өгөгдөл, мэдээлэл нэгтгэгдэнэ. Мэдээллийн сангийн найдвартай аюулгүй байдлыг хангах үүднээс Үндэсний дата төвд мэдээллийн сангийн нөөц сервер байрлана.

7.6. Сүлжээний холболт, түүний тохиргоо болон мэдээллийн системийн аюулгүй байдал, хэвийн ажиллагаа, мэдээллийн санг серверт суулгах, тохируулах асуудлыг Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан гүйцэтгэнэ.

Найм. Мэдээлэл солилцох, мэдээллээр үйлчлэх

8.1 Цахим үйлчилгээ ашиглан олон нийтэд авто замын мэдээллээр үйлчлэх ажлыг Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага зохион байгуулна.

8.2 Мэдээллийн сангаас ерөнхий мэдээллийг үнэ төлбөргүй авах бөгөөд нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн албан бичгээр хүсэлт гаргаж

авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан үнэ тарифын дагуу төлбөртэйгээр авч болно. Төлбөртэй түгээх мэдээллийн төрөл, төлбөрийн хэмжээг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.
/Статистикийн газрын үнэлгээ, Архивын газрын үнэлгээ харах/

8.3 Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагад байрлах үндсэн сервер нь бусад байгууллагуудтай холбогдон энэ журмын хүрээнд мэдээлэл солилцож болох бөгөөд тухайн асуудлыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулна.

Ес. Хориглох зүйл, хүлээлгэх хариуцлага

9.1 Мэдээллийн санд нэвтрэх эрх бүхий этгээд нь мэдээллийн сангийн нууц мэдээлэл, файлын бүтэц, зохион байгуулалтын талаар аливаа мэдээллийг бусдад дамжуулахыг хориглоно.

9.2 Мэдээллийн сангийн серверт эрх бүхий этгээдээс бусад хүн хандахыг хориглоно.

9.3 Энэхүү журмын заалтуудыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, албан тушаалтанд “Авто замын тухай” хууль, “Зөрчлийн тухай” хууль холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох бөгөөд маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

- оОо -

Хавсралт-1

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэлийн маягтууд

| д/д | Тооллогын бүртгэл гаргах зам, замын байгууламжийн нэр | Маягтын дугаар |
|------------|--|-----------------------|
| 1 | Авто зам | ТБ-01 |
| 2 | Гүүр | ТБ-02 |
| 3 | Хоолой | ТБ-03 |
| 4 | Хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээ, заалт, замын бусад тоноглол | ТБ-04 |
| 5 | Замын бусад /давуулах далан, хамгаалалтын хийцүүд, бэхэлгээтэй шуудуу, уулын шуудуу г.м/ байгууламжууд | ТБ-05 |
| 6 | Замын дагуух үйлчилгээний /зогсоолын талбай, нийтийн үйлчилгээний газрууд, замын хэсгүүд, төлбөр хураах цэг, хөд.эрчмийн тооллогын цэг, пүү г.м/ объектууд | ТБ-06 |
| 7 | Замын зурвас дахь ногоон байгууламжууд | ТБ-07 |
| 8 | Цас, халиа тошин, уруйнаас хамгаалсан хийцүүд | ТБ-08 |

